



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 04 сарын 30 өдөр

Дугаар 135

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт, 11 дүгээр зүйлийн 9 дэх заалт, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Үйлдвэрлэл, ажил үйлчилгээний үр дүнд бий болсон, нийт 11,978,400.00 (арван нэгэн сая есөн зуун далан найман мянга дөрвөн зуун) төгрөгийн хавсралтад заасан хөрөнгө (хувилагч машин)-ийг Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн үндсэн хөрөнгийн дансанд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Билгүүн, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал С.Энхцэцэг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ГАНБАТ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД



0000247

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2019 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн
 135.. дугаар тооллын хавсралт



ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН БАЛАНСАД БҮРТГЭХ ҮНДСЭН ХӨРӨНГӨ

Д/д	Хөрөнгийн нэр, марк	Ашиглалтад орсон он	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын нийт үнэ (төгрөг)
1	Хувилагч машин (дижитал принтер, bizhub с 258)	2018	Ш	1	11,978,400.00	11,978,400.00
	Нийт дүн					11,978,400.00 (арван нэгэн сая есөн зуун далан найман мянга дөрвөн зуун)